

**УЛСЫН ИХ ХУРЛЫН 2017 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ
ЧУУЛГАНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДРИЙН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ**

| № | Баримтын агуулга | Хуудасны дугаар |
|----------|--|------------------------|
| 1 | Хуралдааны товч тэмдэглэл | 2-12 |
| 2 | Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл | 13-106 |
| | 1.Ерөнхий сайдын мэдээлэл. “Монгол Улсын Засгийн газар, Олон Улсын банк санхүүгийн байгууллагуудын хамтын ажиллагаа”-ны талаар | 13-26 |
| | 2.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2018-2019 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон холбогдох бусад хуулиудын төслийн үзэл баримтлалыг хэлэлцэх эсэх /Засгийн газар 2017.03.24-ний өдөр өргөн мэдүүлсэн/ | 26-62 |
| | 3.Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн бусад хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг хэлэлцэх эсэх /Засгийн газар 2017.03.24-ний өдөр өргөн мэдүүлсэн/ | 62-85 |
| | 4.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудын төсөл /Засгийн газар 2016.10.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжилнэ/ | 85-101 |
| | 5.Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар анхдугаар зөвлөлдөх санал асуулга явуулах, Зөвлөлдөх зөвлөлийг байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл | 101-108 |

**Монгол Улсын Их Хурлын 2017 оны хаврын ээлжит чуулганы
4 дүгээр сарын 07-ны өдөр /Баасан гараг/-ийн
нэгдсэн хуралдааны гар тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга М.Энхболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 76 гишүүнээс 40 гишүүн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 22 минутад Төрийн ордны Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны танхимд эхлэв.

Чөлөөтэй: Н.Амарзаяа, О.Баасанхүү, Б.Бат-Эрдэнэ, Л.Болд, Ц.Даваасүрэн, С.Жавхлан, Г.Мөнхцэцэг, Д.Мурат, Б.Наранхүү, Н.Оюундарь, Ц.Цогзолмаа, Л.Энхболд, Н.Энхболд;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Батболд, Ц.Гарамжав;

Тасалсан: Ч.Улаан, Д.Цогтбаатар, С.Эрдэнэ.

Хэлэлцэх асуудлын дараалалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Аюурсайхан үг хэлэв.

.....

Тав.Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар анхдугаар зөвлөлдөх санал асуулга явуулах, Зөвлөлдөх зөвлөлийг байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Үндэсний статистикийн хорооны дарга А.Ариунзаяа оролцов.

Хуралдаанд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Өлзийсайхан, зөвлөх Б.Батдэлгэр, референт Б.Төгсцэнгэл нар байлцав.

Төслийг хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Нямдорж, Ц.Мөнх-Оргил нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд үг хэлээгүй болно.

М.Энхболд: -Байнгын хорооны саналаар Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар анхдугаар зөвлөлдөх санал асуулга явуулах, Зөвлөлдөх зөвлөлийг байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 38

Татгалзсан: 8

Бүгд: 46

82.6 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга М.Энхболд “Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар анхдугаар зөвлөлдөх санал асуулга явуулах, Зөвлөлдөх зөвлөлийг байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /20:21 цагт/

Бусад: Улсын Их Хурлын гишүүн О.Содбилэгийн урилгаар Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн Өөрөө нутаглах хэсгийн эмэгтэйчүүдийн бүлгийн гишүүд, Улсын Их Хурлын гишүүн Д.Сумъяабазарын урилгаар “Усан долгио” клуб төрийн бус байгууллагын гишүүд, Улсын Их Хурлын гишүүн С.Жавхлангийн урилгаар Нийслэлийн 7 дугаар дунд сургуулийн 8а ангийг 1976 онд төгссөн төгсөгчдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Д.Гантулгын урилгаар Баянзүрх дүүргийн Татварын албаны албан хаагчид Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдааны бэлтгэл, зохион байгуулалтын үйл ажиллагааг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн асуудал хариуцсан нарийн бичгийн дарга Д.Амгалан, Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Цогтсайхан, мөн хэлтсийн шинжээч Б.Баярсайхан, Р.Дэлгэрмаа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 5 цаг 00 минут үргэлжилж, 76 гишүүнээс 46 гишүүн ирж, 60.5 хувийн ирцтэйгээр 20 цаг 22 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТАМГЫН ГАЗРЫН ЕРӨНХИЙ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Ц.ЦОЛМОН

Тэмдэглэл хөтөлсөн:
ПРОТОКОЛЫН АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2017 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ
ЧУУЛГАНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДРИЙН
/БААСАН ГАРАГ/-ИЙН НЭГДСЭН ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

М.Энхболд: - Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Байнгын хороод хуралдаад дууссан байна. Ингээд 2017 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдааныг эхэлье. Ирц 52.6 хувьтай байна. Хуралдаан эхэлж байна.

Төсөв дууссан уу тийм ээ? Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1 дүгээрт Ерөнхий сайдын мэдээлэл. Монгол Улсын Засгийн газар олон улсын банк санхүүгийн байгууллагуудын хамтын ажиллагааны талаар сонсгол тавина. 2 дугаарт Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн бусад хууль, Улсын Их Хурлын тогтоолын төсөл, хэлэлцэх эсэх байгаа. 3 дугаарт Монгол Улсын нэгдсэн төсвийн 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2018-2019 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төсөл, 4 дүгээрт Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, анхны хэлэлцүүлэг, 5 дугаарт “Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлаар анхдугаар зөвлөлдөх санал асуулга явуулах, зөвлөлдөх зөвлөлийг байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоол байгаа. Ийм 5 асуудлыг хэлэлцэхээр танилцуулж байна.

.....

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар анхдугаар зөвлөлдөх санал асуулга явуулах Зөвлөлдөх зөвлөлийг байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Лүндээжанцан танилцуулна. Лүндээжанцан гишүүнийг индэрт урьж байна.

Д.Лүндээжанцан: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ

Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдаад 25 жил болж байна. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2000,

2011, 12, 15 онуудад Монгол Улсын Их Хурлын гишүүдээс Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байсан.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар Улсын Их Хурлаас байгуулагдан ажиллаж байсан ажлын хэсгүүдээс болон иргэд, эрдэмтэн, судлаачдаас тодорхой санал, дүгнэлтүүдийг энэ хугацаанд гаргасан байна. Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар холбогдох санал боловсруулах үүрэг бүхий Үндсэн хуулийн асуудлаар мэргэшсэн эрдэмтэн, судлаачдаас бүрдсэн ажлын хэсгийг Монгол Улсын Засгийн газраас байгуулан ажилласан билээ.

Эдгээр санал, дүгнэлтүүдийг үндэслэн Төрийн байгуулалтын байнгын хороо Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль болон Зөвлөлдөх санал асуулгын тухай хуульд зааснаар Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар анхдугаар зөвлөлдөх санал асуулга явуулах, Зөвлөлдөх зөвлөлийг байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг санаачлан боловсрууллаа.

Байнгын хороо тогтоолын төслийг 2017 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд, Зөвлөлдөх санал асуулгын тухай хуульд заасны дагуу Зөвлөлдөх санал асуулга явуулах сэдэв, хугацаа, газар нутаг, төсвийг тогтоолын төсөлд тусгасан болно. Зөвлөлдөх зөвлөлийн бүрэлдэхүүнийг тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлахаар заасан. Зөвлөлдөх санал асуулгын сэдвийг Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.3 дахь заалтын дагуу 6 ерөнхий заалт, 13 дэд заалттайгаар боловсруулж, тогтоолын 02 дугаар хавсралтаар батлахаар тусгалаа.

Байнгын хорооны хуралдааны үеэр Улсын Их Хурлын гишүүд санал асуулгын үр дүнд гарах шийдвэр, хэлэлцүүлгийн үйл явц, зөвлөлдөх зөвлөлийн бүрэлдэхүүн, санал асуулгын сэдвийн талаар асуулт асууж, хариулт авсан.

Улсын Их Хурлын гишүүн Л.Оюун-Эрдэнэ шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах ёстой Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүн, шүүгч, ерөнхий шүүгчийг томилох томилгооны зарчмыг тодорхой болгох, Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат тогтоолын төслийн гарчигт Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар анхдугаар зөвлөлдөх санал асуулга гэх тодотгол нэмэх, Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан санал асуулгыг орон даяар явуулах тухай тодорхой тусгах, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзандан санал асуулгын сэдвийн 6 дахь заалтын шатлал бүхий гэснийг хасах, Улсын Их Хурлын гишүүн О.Содбилэг санал асуулгын үйл ажиллагаанд залуу үеийн төлөөллийг оролцуулах, мөн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх зөвлөлдөх санал асуулгын талаар олон нийтэд тайлбарлан таниулах нь зүйтэй гэсэн саналуудыг гаргасан.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар анхдугаар зөвлөлдөх санал асуулга явуулах Зөвлөлдөх зөвлөлийг байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулах нь зүйтэй гэсэн саналыг хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтгэйгээр дэмжсэн болно.

Тогтоолын төсөл, Байнгын хорооны санал, дүгнэлт болон холбогдох мэдээллийг та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар анхдугаар зөвлөлдөх санал асуулга явуулах Зөвлөлдөх зөвлөлийг байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс эрхэмлэн хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

М.Энхболд: Лүндээжанцан даргад баярлалаа. Ажлын хэсэгт: Үндэсний статистикийн газрын дарга Ариунзаяа ирсэн байна.

Байнгын хорооны санал, дүгнэлтээс асуулт асуух хүн байна уу? Мөнх-Оргил гишүүнээр тасаллаа. Нямдорж гишүүн асуулт асууж, үг хэлнэ, хамтдаа.

Ц.Нямдорж: Ингээд зөвлөлдөх санал асуулга гээд нэг юм хийчих юм байна. Түүний дараа чинь санал асуулга гээд жинхэнээсээ дахиад хоёр дахиа хийх үү? Нөгөө Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн заалт чинь юу болох вэ? Ард нийтийн санал асуулгын хууль чинь юу болох вэ? Энэ ер нь ямар учиртай юм болоод байна вэ? Зардал яаж гаргах гэж байгаа юм? Хэчнээн юм гарах вэ? Тэгээд энэ чинь яг амьдрал дээрээ очоод нөгөө сонгуульд санал хураадаг шиг цаасан дээр санал хураах юм уу? Яах юм? Ер нь юу хийх гээд байна? Намын хурал маягийн юм болох юм уу? Иргэдийн Хурал маягийн юм болох юм уу? Тэгээд үүнийгээ нэг хэлээд өгчихвөл зүгээр байх юм. Зардлыг нь хамгийн гол яах гэж байгаа юм. Тэгээд энэ чинь баахан санал юм гээд хүрээд ирдэг, дараа нь энэ чинь болох юм байна гээд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт боловсруулдаг. Тэгээд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн чинь ард нийтийн оролцоогүйгээр болохгүй гээд байгаа шүү дээ, одоо зарчим нь. Тэгээд санал асуулга явуулах гээд байгаа шүү дээ.

Энэ өнгөрсөн Их Хурлын үед та нар чинь Үндсэн хуулийн өөрчлөлтийн юм оруулаад санал асуулгаар шийдүүлнэ гээд давхиад бараг алах шахаад тэгээд замд нь нэг юм онхолдож унасан байх аа. Бас нэг ийм юм болох юм уу? Хэзээ үүнийгээ дуусгах юм бэ? Энэ Үндсэн хуулийн өөрчлөлтийг чинь. Их л будлиантай юм л, зураг харагдаад байна даа наадах чинь. Эсэргүүцэж байгаа юм биш, үүнийг ойлгомоор байна. Энэ чинь ямар юм болох гээд байгаа юм?

М.Энхболд: Лүндээжанцан гишүүн хариулъя.

Д.Лүндээжанцан: Би ер нь энгийн байдлаар тайлбарлая. Ер нь бол нээрээ иргэд бас л гайхаж байгаа л даа, энэ дээр. Бид Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулиар энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэх, боловсруулахаасаа авхуулаад хэлэлцэж батлах хүртэлх процесс явагдана. Яг үүнийхээ хүрээнд явагдах ёстой. Дээр нь Зөвлөлдөх санал асуулгын хуулийг бид өнгөрсөн намрын чуулганаар батлан гаргасан. Ингээд энд бол Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын хуульд нэмэлт, өөрчлөлт

оруулаад, 5.3.4, 5.3.3-т Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 20 дугаар зүйл, 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 41 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар Зөвлөлдөх санал асуулгыг явуулах гээд, заавал явуулна гэдэг заалтыг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах журмын хуульд заагаад өгчихсөн байгаа.

Тэгэхээр бид нарын энэ оруулж ирж байгаа асуудлууд бол голдуу түүнтэй холбоотой. Зарим өөрчлөлт оруулах асуудлыг Зөвлөлдөх санал асуулгад оруулахгүй байж болно. Гарцаагүй оруулах хэдэн заалтыг нь энд оруулж өгсөн учраас Зөвлөлдөх асуулга явуулахгүйгээр Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах аргагүй болчихоод байгаа юм. Энэ заалтын дагуу Зөвлөлдөх санал асуулга, хэрвээ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулья гэвэл заавал Зөвлөлдөх санал, асуулга явуулах болж байна. Энэ заалтад хамаарахгүй зүйлүүдэд өөрчлөлт оруулахаар бол явуулахгүй байж болно гэж.

Дараагийн асуудал нь, Зөвлөлдөх санал, асуулгын тухай хуулийн 6.1.1-д заасны дагуу явуулсан санал асуулгын дүнгээр Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг дэмжсэн бол Улсын Их Хурал заавал авч хэлэлцэх бөгөөд шаардлагатай бол Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулна гээд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын хуульд заачихсан.

Ийм учраас би юу гэж харж байна вэ гэвэл, энэ Зөвлөлдөх санал асуулгын 6 сэдэв гэдгийг та бүхэнд тараачихсан байж байгаа. Энэ 6 сэдэв дээр хэд нь дэмжигдэж, хэд нь дэмжигдэхгүй байхыг хэлж мэдэхгүй. Ингээд гараад ирсний дараагаар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг боловсруулах комиссыг Улсын Их Хурлын тогтоолоор байгуулж таарна. Тэгээд тэр нь Улсын Их Хуралд оруулж ирээд, Улсын Их Хурал нэг бүрчлэн хэлэлцээд, тэгээд шүүрэн шанаган дээр юу үлдэж хоцрох вэ? Яг түүнийг нь ард түмний нийтийн санал асуулгад оруулах асуудал яригдахаар ийм үе шаттай, олон шат дамжлага бүхий, яагаад гэхээр энэ чинь Үндсэн хууль шүү дээ. Тийм учраас Үндсэн хуульд нягт нямбай хандах ийм шаардлага байгаа учраас 7 хэмжиж, 1 огтол гэдэг зарчмыг одоо энэ олон өргөстэй цоожийг суулгаж өгсөн юмаа.

Хоёр дахь нь, тэр Зөвлөлдөх санал асуулга гэж юугаа хэлээд байгаа юм бэ гэж. Тэгэхээр Зөвлөлдөх санал асуулгын тухайд энэ хууль дээрээ дэлгэрэнгүй заачихсан. Жишээ нь, санамсаргүй түүврийн аргаар Монгол Улсын нийгмийн бүх давхаргын төлөөллийг оролцуулсан. Оролцуулахдаа тодорхой тооны төлөөллүүдийг авчраад, түүнээсээ дахиад 50 хувийг нь гээд, ингээд 400-500 хүнийг Их Хурлын танхимд 4 сарын 29-30-ны өдөр тэр Зөвлөлдөх санал асуулгыг явуулна. Тэгэхээр баримт нотолгоонд суурилсан, тогтвортой, тэнцвэртэй мэдээллийг ирсэн хүмүүстээ өгнө. Тэд жижиг бүлгүүдээр зөвлөлдөж, ярилцана, асууж мэтгэцэлнэ, асуудлыг олон талаас нь харьцуулсан, тэнцвэртэй, бодитой мэдээлэлтэй болсны үндсэн дээр санал, дүгнэлтээ гаргах боломжоор хангана. Тэгээд модераторууд гээд хөтлөгчдийг бэлтгэнэ, бэлтгэгдэнэ. Танилцах материал бэлтгэнэ. Маш энгийн ойлгомжтой, нэг талыг барьсан бус, эерэг . . ./хугацаа дуусав/.

М.Энхболд: Лүндээжанцан гишүүнд 1 минут нэмж өгье.

Д.Лүндээжанцан: 1 минутад багтаахыг бодъё. Тэгэхээр ингээд ойлгомжтой 15-аас илүүгүй гээд бүр хуульд нь заачихсан байгаа шүү дээ. 15, 15-аар нь бүлэглээд, тэгээд хоорондоо мэтгэлцээд, ингээд бүх эерэг тусгасан материалыг уншиж судална. Нэг талыг ерөөсөө барьж болохгүй гээд. Ингээд хамгийн сүүлд нь хоёр өдөр ярилцаад, тэгээд бололцоотой мэдээллээр өмнө нь хангаад, хооронд нь ярилцуулаад, тайлбарлаад, тэгэхдээ нэг талыг ерөөсөө барьж болохгүй. Ингээд хамгийн сүүлд нь тэр нууц санал хураалт явуулна. Тэгээд энэ яаж дэмжигдэв гэдэг нь гарна. Энэ дээр нь шинжээчид ажиллана. Тэгээд зөвлөлдөх зөвлөл гэж байгуулсан тэр хүмүүс нь энэ бүхэн дээр дүн шинжилгээ хийсэн юмыг нэгтгээд зөвлөмжийг Улсын Их Хуралд оруулна.

Тэгээд энэ Үндсэн хуульдаа бид яаж нэмэлт, өөрчлөлт оруулах вэ гэдгээ Их Хурал ярилцах бүрэн эрх нь нээгдэж байгаа юм.

М.Энхболд: Мөнх-Оргил гишүүн. 250 сая төгрөг Засгийн газрын нөөцөөс гарга гээд орчихсон юм байна, тогтоолд.

Ц.Мөнх-Оргил: Лүндээжанцан гишүүн ээ, энэ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг эхлүүлэхийг би бол хувьдаа жишээ нь дэмжиж байна. Гэхдээ энэ чухал энэ чинь зүгээр нэг хууль биш шүү дээ, Үндсэн хууль. Энэ том хуульд оруулах гэж байгаа ийм зарчмын өөрчлөлтүүдийг арай л хурдан, ороо бусгаа аргаар шийдэх гээд байгаа юм бишүү гэж би санаа зовоод байна. Жишээ нь бид нар Зөвлөлдөх санал асуулга явуулах хуулийг дөнгөж сая батлаад, Монгол улсдаа бид нар Зөвлөлдөх санал асуулгаар нэг ч юм хэлэлцэж үзээгүй байгаа. Яаж хэлэлцдэг нь мэдэхгүй, зөвлөлдөх санал асуулгаа бид нар үзээгүй байгаа, Үндсэн хуулиа яаж өөрчлөх вэ гэдгээ бид нар яриад байсан. Зөвлөлдөх санал асуулгаа бид нар хийж үзээгүй байгаа.

Ер нь бол эндээс ингээд уншихаар, Зөвлөлдөх санал асуулгаар бүх нийтийн хэлэлцүүлгийг солих гээд байна. Үндсэн хуулийг бид нар 1992 онд батлахдаа бүх нийтийн хэлэлцүүлэг явуулж байж, хэдэн сараар нь, одоо би санахгүй байна, 9 сар ч билүү бүх нийтээрээ хэлэлцүүлээд, аймаг, сум, дүүрэг бүгдээрээ саналаа хэлээд, Ардын Их Хуралдаа саналаа явуулаад, ингээд бүх нийтийн хэлэлцүүлэг болж байж нийгэм даяараа -аа Үндсэн хуульд ийм ийм санаа орох юм байна, энэ нь зөв юм байна, үүнийг нь дэмжих хэрэгтэй юм байна гээд нийгмээ бүхэлд нь мэдээллээр хангаж байж, бид нар энэ Үндсэн хуулиа баталсан учраас Үндсэн хууль нь суурьтай, дэвсгэртэй, өнөөдөр ямар нэгэн байдлаар улс орны амьдралыг зохицуулаад явуулаад байгаа юм.

Гэтэл энэ нийтийн хэлэлцүүлгийг өнөөдөр Зөвлөлдөх санал асуулга гэдэг юмаар 2 өдрийн дотор явуулж, зөвлөлдөх санал асуулгаар солих гээд байна шүү дээ. Ингэж болж байгаа юм уу? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, энэ дотор жишээ нь миний бодлоор бол Үндсэн хуулийн суурь зарчим уруу жинхэнэ сэлэм жад болж орж байгаа заалт бол жишээ нь 4.1-д байж байна. Монгол Улсын нутаг дэвсгэр Засаг захиргааны хувьд аймаг, нийслэл, хотод хуваагдана гэж байгаа юм. Яаж ямар ч улсын засаг захиргааны нэгж чинь аймаг, нийслэлдээ хуваагдаж болно. Тэгэхдээ хот гэж хуваагдахгүй шүү дээ. Хот гэдэг чинь засаг захиргааны нэгж биш. Хот гэдэг чинь яг нарийндаа ярих юм бол аж ахуйн байгууллага байгаа юм. Тэнд суурин амьдарч байгаа хүмүүсийн нийтийн,

нийгмийн асуудлуудыг шийддэг зохион байгуулалттай нэгж болохоос биш засаг захиргааны нэгж биш байхгүй юу? Сумын нутаг дэвсгэр дээр хот байж болно.

Аймаг нь хотдоо эрх мэдлээ шилжүүлж болно, хөрөнгө мөнгөө шилжүүлж болно. Гэхдээ улсаа бид нар аймаг, нийслэл, аймаг нийслэлээ дүүрэг, сумд хуваачаад, тэгээд дээр нь сумаа дахиад бид нар хотод хувааж болохгүй. Энэ чинь ерөөсөө Үндсэн хуулийн суурь зарчимтай шууд зөрчилдөөд явж байна шүү дээ. Ийм юмыг бид нар хэлэлцүүлэгт оруулахаар 2 өдрийн дотор үүний ялгаа, салгааг гаргаж чадахгүй. 2 өдрийн дотор ялгаа, салгааг гаргаж чадахгүй бол бид нар 10-20 хэдэн жил бид нар хот ингээд хөгжихгүй байгаа юмаа, аймгийн төв чинь хот учраас хот жинхэнэ утгаараа хөгжихгүй байгаа юм. Тийм учраас Үндсэн хуулиндаа хот гээд оруулчих юм бол асуудал шийдэгдэх гээд байна гээд Үндсэн хуулийнхаа суурь зарчмыг зөрчөөд явчих гээд байна шүү дээ. Эд нарыгаа яаж хэзээ энэ олон ялгаа салгааг нь гаргаж хэлэх юм бэ? Арай л түргэн шуурхай юм биш үү? Сайнаар хэлэх юм бол. Муугаар хэлэх юм бол арай гоомой юм биш үү? Лүндээ дарга аа.

М.Энхболд: Лүндээжанцан гишүүн хариулъя.

Д.Лүндээжанцан: Энэ хот гэдэг үгийг засаг захиргааны нэгж болгох асуудлаар 27 жил ярилаа, гоомой юм биш. Дархан, Эрдэнэт хоёрыг хот нь тэгэхээр та бүхэн уншиж байгаа байх, та бүхэнд тараагаад өгчихсөн. Монгол улсын нутаг дэвсгэр, засаг захиргааны хувьд аймаг, нийслэл, хотод, аймаг нь сум, хотод, тэр нь орон нутгийн харьяалалтай хотыг хэлж байгаа юм. Аймгийн төвүүд, зарим аймгууд нь Зүүнхараа, Хархорин, Тосонцэнгэл ч гэдэг юм уу? Ингээд аймгийн хоёр янзын хот гарна. Нэг нь аймагтай ижилхэн хот, нөгөө дэх нь орон нутгийн харьяалалтай хот, сумтай адилхан хот. Сум нь болоод ирэхээр баг, тосгонд. Зарим газар бол тосгонтой сумууд байж байна. Тэгэхээр үүнийг бол баг, тосгонд гэж ангилж авч үзсэн. Энэ судалгааг бид олон талаас нь хийсэн. Олон эрдэмтэн, судлаачдын асуудал бол яригдсан. Хэд хэдэн төслүүд Үндсэн хуулийн Их Хурал дамжиж өргөн баригдаж хэлэлцэгдсэн. Тэгэхээр энэ дотор орсон сэдвүүд болгон 6 сэдэв, 13 дэд сэдэв. Энэ 13 зүйл бол нийтдээ 20 гаруй зүйлд өөрчлөлт орохоор орж ирснээс ингээд хумигдаад байна шүү дээ. Бүр зарим нь шинэ Үндсэн хуулийн тухай ярьдаг.

Шинэ Үндсэн хуулийн тухай асуудлыг бид зөвхөн нэмэлт, өөрчлөлтийн хэмжээнд л авч үзнэ. Нэмэлт, өөрчлөлт нь 34 хувиас хэтэрч болохгүй. Тэгэхээр энэ хэмжээний юмнуудыг авч үзэхийн тулд энэ заалтуудыг олон шүүлтүүрээр авч үзсэн. Та бүхний гар дээр асуулгын судалгааны дүн байгаа байх. Сая Засгийн газар дээр байгуулагдсан ажлын хэсэг бол нийтдээ нийслэлийн 2 дүүрэгт амжаагүй байна, бусад бүх аймаг, хотуудаар судалгаа явуулсан, асуулгын судалгаа. Дээр нь бүх аймагт очиж хэлэлцүүлэг зохион байгуулсан. Мөн одоо энэ тогтоол дотор орон даяар гэж байгаа юм. Зөвлөлдөх санал асуулга эндээ хийнэ. Дээр нь аймаг болгонд аймгийн иргэдийн Хурал, Засаг даргын Тамгын газар нөөц бололцоондоо тулгуурлаад, аймаг, зарим томоохон сумдууд ингэж орон даяар хэлэлцүүлгүүдийг зохион байгуулна. Гэхдээ бидэнд хугацаа ямар ч байсан энэ нэмэлт, өөрчлөлтийн асуудлыг хөдөлгөө.

Тэгээд би хэлээд байна шүү дээ, гоомой хандаж болохгүй гэж яриад, би түүний талд байдаг, хатуу зогсдог хүн нь. Тийм учраас асуудалд гоомой

хандуулахгүйн тулд л энэ их хугацааг зарсан. Тэгээд одоо ямар ч байсан энэ 13 зүйлийг ард нийтээрээ хэлэлцүүлэхдээ мэдээлэлтэй хүмүүсээр мэтгэлцүүлж байгаад дараа нь саналыг нь хурааж хэлэлцүүлье. Манай философид байдаг шүү дээ. Дэлхий хавтгай юу гээд ард нийтээр гар өргүүлээд санал хураасан чинь хавтгай гэж олонх нь өргөсөн ийм түүх бидний түүхэнд байж л байгаа, дэлхийн түүхэнд. Түүнтэй адилхан эхлээд бол бид Зөвлөлдөх санал асуулга гэдэг бол мэдээлэлжүүлж байгаад бэлтгэж байгаад хураалгаад үзье. Тэгээд түүн дээр нь комисс гаръя. Тэгээд Их Хурал нэг бүрчилж бүх зүйлийг цэг, таслалаар нь хэлэлцье. Тэгээд юу нь үлдэх нь вэ? Түүнийг ард нийтийн санал асуулгад оруулъя гэсэн ийм шат дамжлагатайгаар олон шүүлтүүрээр явна.

Санхүү, төсвийн хувьд 250 сая төгрөг байгаа. Үүнийг Төсвийн тодотголоор суулгана гээд Засгийн газартай хэлэлцэж тохирсон байгаа. Тэгэхээр бид захиргааны байгууллагууд болоод төрийн захиргаа, дээр нь иргэдийн Хурал нөөц бололцоогоо ашигласны үндсэн дээр аль болохоор эдийн засаг хүндрэлтэй байгаа үед бололцооны хэмжээний төсөв л гэж ингэж үзэж байгаа юм.

Ер нь бол Улсын Их Хурлын Тамгын газрын аппарат тэр чигтээ, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, аймаг, орон нутгийн Тамгын газар, нөгөө Төрийн захиргаа, удирдлагын хэлтэс, иргэдийн Хурлууд ажлын аппаратууд тэр чигтээ ажиллана. Тэгээд статистикийн хороо орон нутгаар энд байгаа 130 хэдэн хүн бэлтгэгдэж, семинарлагдаж байгаа. Бүтнээрээ ажиллах юм.

М.Энхболд: Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Одоо Байнгын хорооны саналаар Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар анхдугаар зөвлөлдөх санал асуулга явуулах Зөвлөлдөх зөвлөлийг байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

46 гишүүн оролцож, 38 гишүүн дэмжиж, 82.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Санал дэмжигдсэн тул тогтоолын төсөл шууд батлагдаж байна гэсэн үг.

Би эцсийн найруулгыг та бүхэнд уншиж танилцуулъя.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар анхдугаар зөвлөлдөх санал асуулга явуулах Зөвлөлдөх зөвлөлийг байгуулах тухай.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай журмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.3 дахь заалт, Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалт, 6.2 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн, 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Зөвлөлдөх санал асуулгыг орон даяар Төрийн ордны Их танхимд 2017 оны 4 дүгээр сарын 29-30-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2.Зөвлөлдөх зөвлөлийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар, Зөвлөлдөх санал асуулга явуулах сэдвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Зөвлөлдөх санал асуулгын төсвийг 250 сая төгрөгөөр баталж, санхүүжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т үүрэг болгосугай.

4.Зөвлөлдөх санал асуулгын дүнг нэгтгэж, зөвлөмж гарган Улсын Их Хуралд танилцуулахыг Зөвлөлдөх зөвлөлд даалгасугай.

5.Зөвлөлдөх санал асуулга зохион байгуулахад туслалцаа үзүүлэх, ажлын хэсэг байгуулах, ажлын төлөвлөгөө батлахыг Төрийн байгуулалтын байнгын хороо /Н.Энхболд/-нд үүрэг болгосугай.

6.Энэ тогтоолыг 2017 оны 4 дүгээр сарын 7-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Үүгээр өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлуудыг хэлэлцэж дууслаа. Чуулган өндөрлөж байна. Гишүүд сайхан амарцгаагаарай.

Дууны бичлэгээс буулгасан:
ПРОТОКОЛЫН АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА